



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 16 өдөр

Дугаар A/65

Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож, захиалагчийн төлөөлөгч томилж, ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 45 дугаар зүйлийн 45.3, 46 дугаар зүйлийн 46.1.3, 46.1.6, 46.3, Засгийн газрын 2021 оны “Журам батлах тухай” 160 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2022 оны “Байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг батлах тухай” А/95 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/191 дүгээр тушаалаар байгуулсан үнэлгээний хорооны шийдвэрийг үндэслэн Цэцэрлэгийн барилга, 150 ор (Хөвсгөл, Мөрөн 2-р дугаар цэцэрлэг) төсөл арга хэмжээний зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээг барилгын ажлын гүйцэтгэлээс санхүүжүүлэх ХӨАОНӨГ/202312233 дугаартай тендерт 43,956,000 (Дөчин гурван сая есөн зуун тавин зургаан мянган) төгрөгийн үнийн санал ирүүлсэн “Креатив энержи инженеринг” ХХК-ийн тендерийг зөвшөөрч, тус компанид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2.“Креатив энержи инженеринг” ХХК-ийн гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, холбогдох шийдвэрийг гаргах, зөвлөх үйлчилгээний гэрээний нөхцөлүүдийн хэрэгжилтэд хяналт тавих зөвлөх үйлчилгээг хүлээн авах, гэрээ дүгнэх чиг үүрэг бүхий “Захиалагчийн төлөөлөгч”-өөр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-г томилж, зөвлөх үйлчилгээ хүлээн авах, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Оюунтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Ажлын хэсгийн гишүүд: Б.Баасанжав (Барилгын материалын үйлдвэрлэл, лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Х.Даваасүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, аймгийн ерөнхий архитектор)

3. Цэцэрлэгийн барилга, 150 ор (Хөвсгөл, Мөрөн 2-р дугаар цэцэрлэг) төсөл арга хэмжээний зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээнд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, гэрээний хэрэгжилтийг хангах, зөвлөх үйлчилгээг хүлээн авах, гэрээг дүгнэх, санхүүжилтийн гүйцэтгэл баталгаажуулах, гэрээ болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх цогц системд тус тус нийтлэх, захиалагчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжүүлсэн тухай ажлын үр дүнг тайлагнах, тайланг хаваст хэрэг болгон архивт шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг захиалагчийн төлөөлөгч (Б.Оюунтуяа)-д, захиалагч, тендерт оролцогч (тухайн тендерт оролцсон нийт оролцогч)-ийн тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан баримт бичиг, гэрээ дүгнэсэн акт, зөвлөх үйлчилгээ хүлээн авсан шийдвэр, санхүүжилтийн гүйцэтгэл зэрэг баримт бичгийг цахим болон бичгийн хэлбэрээр хаваст хэрэг болгон аймгийн Худалдан авах ажиллагааны газрын архивт шилжүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Д.Даваасамбуу)-д тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсорогдог)-д үүрэг болгосугай.



2. Креатив энэхүү инженерийн эхийн гаралтай хөгөөстөй асуудлаар захиалагчийг төлөө ор хөснэгэх, хоногдох шийдвэрийг гаргах, зөвлөх үйлчилгээний төрөлч нийтийн түүрүүдийн төрөлжилтийг хяналт таажа автолек үйлчилгээг хийж газар төхөн чигүүрийн буюу "Захиалагчийн төлөөлөгч"-ээр эмчилжээ. Төслийн төрөлчийн төслийн бодлого төвлөлт, хөрөнгө оруулалтын халтсын дарга (Б.Соургуяарт, Гомзэ, зөвлөх үйлчилгээ хүлээн авах, нийтийн төрөлчийн бодлого төвлөлт, хөрөнгө оруулалтын халтсын дарга). Тунд.

Ажлын хасгийн ахлагч: Б.Соургуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төвлөлт, хөрөнгө оруулалтын халтсын дарга)

Ажлын хасгийн төмөрч: Б.Балсанжав (Барилгын материалын үйлдвэрлэл, лабораторийн асуудал харцуулсан мөргжилтэн)

Ажлын хасгийн нарийн бичгийн дарга: Х.Даваасурэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төвлөлт, хөрөнгө оруулалтын халтсын мөргжилтэн, аймгийн хөгжлийн архитектор)